

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2013 оны 01 сарын 11.-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

### *Бодлогын баримт бичиг батлах тухай*

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компани нь хэлбэрээ өөрчилж нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан дараах баримт бичгүүдийг Компанийн засаглалын кодекст нийцүүлэн энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай. Үүнд:
  - 1.1. “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг 1 дүгээр хавсралтаар;
  - 1.2. “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг 2 дугаар хавсралтаар.
2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох хороодод, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





## “СЭНДЛИ ББСБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1.“Сэндли ББСБ” ХК (цаашид “ББСБ” гэх)-ийн эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго нь ББСБ-ын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар ББСБ-ын хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2.Энэхүү бодлогын хүрээнд ББСБ-ын үйл ажиллагаанд үүсэх эрсдэлийн төрөл, эрсдэлийн удирдлагын үндсэн зарчим, арга, аргачлал, эрсдэлийн удирдлагын үйл явц, түүний хамрах хүрээг тогтоох ба эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэх, мөрдөж ажиллах ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлно.
- 1.3.Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь ББСБ-ын бүх газар, нэгж, албан тушаалтан, ажилтанд хамаарна. Ажилтан бүр хариуцаж буй чиг үүргийн хүрээнд эрсдэлийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, үнэлэх, тайлагнах үүрэгтэй.
- 1.4.Эрсдэлийн удирдлагын бодлогын нэр томъёоны тодорхойлолтыг дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.4.1.Эрсдэл-үйл ажиллагааны явцад үүсэх тодорхойгүй нөхцөл байдлыг хэлнэ;
  - 1.4.2.Эрсдэлийн удирдлага - эрсдэлийг тодорхойлох, ангилах, шинжлэх, үнэлэх, хязгаарлах, арга хэмжээ авах, хянах цогц үйл ажиллагааг;
  - 1.4.3.Эрсдэлийн хязгаарлалт/VAR/- тухайн үйл ажиллагаанаас хүлээж болзошгүй хохирлоос сэргийлэхийн тулд тогтоосон хохирлын хязгаарыг;
  - 1.4.4.Стресс тест-эрсдэлийн хүчин зүйлийн магадлал багатай боловч боломжтой өөрчлөлтийн дунд хүлээж болзошгүй хохирлыг тодорхойлох;
  - 1.4.5.Back test- хүлээж байсан эрсдэлийн түвшин хир оновчтой байсныг үнэлдэг загварыг;
  - 1.4.6.Зөрүүний шинжилгээ /GAP/- хүлээж байсан үйл ажиллагааны үр дүнд хүрч чадсан эсэх талаар үнэлдэг;
  - 1.4.7.Буцаан шалгалт- эрсдэлийг тооцоолох загварын илэрхийлэх чадварыг бодит мэдээлэлтэй харьцуулах замаар тодорхойлох;
  - 1.4.8.Онцгой нөхцөл байдал- харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй бодит хүндрэл үүсэхийг;
  - 1.4.9.Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө - онцгой нөхцөл байдал үүссэн үед үйл ажиллагаа болон санхүүжилтийг хэвийн болгоход чиглэсэн хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан баримт бичгийг;
  - 1.4.10. “Дөрвөн нүдний” зарчим - хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах, зарцуулах, нягтлан бодох бүртгэл, тайлагнаалд хоёроос доошгүй ажилтан хяналт тавьж баталгаажуулах;
  - 1.4.11. “Хамгаалалтын З шугам” загвар- учирч болох эрсдэлийг шат дараалсан хяналтын тусламжтайгаар илрүүлэх, удирдахад зориулсан загварыг,
  - 1.4.12. Эрх бүхий албан тушаалтан- ББСБ-ын ТҮЗ-ын дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны чиглэл хариуцсан нэгжийн захирлыг ойлгоно.

- 1.5. ББСБ эрсдэлээ тодорхойлоходоо өөрийн стратегийн хэрэгжилт, үйл ажиллагаанд тодорхойгүй сөрөг нөхцөл байдал үүсэх магадлал болон түүний нөлөөллөөр хэмжинэ.
- 1.6. Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинээр болон шинэчлэн батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталгаажуулна.
- 1.7. Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын удирдах эрсдэлийн төрлүүд, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журмуудыг батлан гаргаж хэрэгжүүлнэ.

### **Хоёр. Эрсдэлийн удирдлагын бодлогын зорилт, үндсэн зарчим**

- 2.1. ББСБ өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг салбарын хэмжээнд хамгийн бага байлгахыг зорино. Эрсдэл, өгөөжийн харьцааг хамгийн оновчтой байлгахын тулд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:
  - 2.1.1. Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог “Хамгаалалтын З шугам” загварын дагуу бүрдүүлэх;
  - 2.1.2. Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах тогтолцоо бүхий мэдээллийн баазыг бий болгох;
  - 2.1.3. ББСБ-ын эрсдэлийн хувь, хэмжээг тогтоосон хязгаарын хүрээнд зохистой түвшинд барьж ажиллах;
  - 2.1.4. Эрсдэлийн хэмжээтэй уялдуулан нөөцийн хуваарилалтыг хийх;
  - 2.1.5. Хүлээгдэж буй ашгийн хэмжээ нь учирч болох эрсдэлийг бүрэн нөхөхеөр байх;
  - 2.1.6. Гүйцэтгэлтэй холбоотой аливаа урамшуулал нь хүлээж буй эрсдэлийн түвшинтэй уялдаж байх;
  - 2.1.7. ББСБ-ын үйл ажиллагааг урт хугацаанд найдвартай байлгах, хэтийн ашигт ажиллагааг осгөхөд хувь нэмэр оруулах;
  - 2.1.8. ББСБ-ын тухайлсан эрсдэл бусад төрлийн эрсдэлтэй салшгүй холбоотой тул цогцоор нь удирдах;
- 2.2. ББСБ нь эрсдэлийг удирдахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 2.2.1. **Хараат бусаар үнэлгээ хийх-** Эрсдэлийн удирдлагыг хариуцсан эрх бүхий албан тушаалтан ББСБ-ын бусад газар, нэгжээс хараат бус ажиллаж, ББСБ-ын эрсдэлийг бодитой, бие даасан байдлаар тодорхойлон үнэлнэ;
  - 2.2.2. **Тайлагнадаг байх-** бүх төрлийн эрсдэлийн тайланг тогтоосон хэлбэр, загварын дагуу тогтмол давтамжтай болон тухай бүр, шуурхай гаргаж, удирдлагад тайлагнана;
  - 2.2.3. **Тогтмол сайжруулан шинэчилж байх-** ББСБ-ын эрсдэлийн удирдлагатай холбоотой эрх зүйн баримт бичгийг эргэн хянаж сайжруулах арга хэмжээг тогтмол авна;
  - 2.2.4. **Хэмжигдэхүйц байх -** эрсдэлийг хэмжихдээ тоон болон чанарын шинжилгээний аргыг ашиглах бөгөөд эрсдэл хэмжигдэхүйц байвал удирдах боломжтой гэсэн зарчимд үндэслэн тоон шинжилгээг суурь арга болгоно;
  - 2.2.5. **Баримтжуулалт хийх-** эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, хязгаар тогтоох, хяналт тавих, тайлгахаа зэрэг эрсдэлийн удирдлагын бүх үйл ажиллагаа, түүнтэй холбогдох шийдвэрийг баримтжуулж, баталгаажуулсан байна;
  - 2.2.6. **Эрх мэдлийн төвлөрлийг хязгаарлах-** ББСБ-д эрсдэл учруулж болзошгүй шийдвэр гаргах эрх мэдлийг нэг албан тушаалтанд төвлөрүүлэхээс зайлсхийж, дөрвөн нүдний зарчмыг баримтлана.
  - 2.2.7. **Эдийн засгийн үр ашигтай байх-** эрсдэлийг удирдах үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь аливаа хохирлыг бууруулахад чиглэсэн байх бөгөөд гарах зардал нь эрсдэлээс үүсэх хохирлоос бага байхад чиглэнэ.

- 2.2.8. Эрдэлийн удирдлага нь ББСБ-ын үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтын иэг хэсэг байх- ББСБ-ын удирдлага, холбогдох эрх бүхий албан тушаалтнууд шийдвэр гаргахдаа эрдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтны бэлтгэсэн тайлан мэдээ, судалгаа шинжилгээтэй танилцаж, харгалзан үзнэ.

### Гурав. Эрдэлийн төрөл

- 3.1. Компанийн эрдэлийг дараах байдлаар ангилна. Үүнд:
- 3.1.1. Зээлийн эрдэл - зээлдэгч болон бусад харилцагч этгээд ББСБ-ын өмнө хүлээсэн гэрээний үүргээ цаг тухайд нь биелэхгүй байх, мөн барьцаа хөрөнгө нь үүргийн гүйцэтгэлийг хангахгүй болохоос үүсэх эрдэлийг;
- 3.1.2. Зах зээлийн эрдэл - зах зээлийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хохирол хүлээх эрдэлийг;
- 3.1.3. Үйл ажиллагааны эрдэл - ажилтны санаатай, санамсаргүй үйлдэл, дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам, заавар, мөн автоматжуулсан систем, гадаад хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хохирол хүлээх эрдэлийг;
- 3.1.4. Хөрвөх чадварын эрдэл - компанийн өөрийн хөрөнгө хүрэлцээтэй боловч бусад хүчин зүйлийн нөлөөллөөр аливаа гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нехцэл байдал үүсэх эрдэлийг хэлнэ.
- 3.1.5. Нэр хүндийн эрдэл - Компанийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээлэл олон нийтэд тархасны улмаас одоо болон ирээдүйд орлого буурах, тооцоолоогүй зардал гарах зэрэг эрдэлийг хэлнэ.
- 3.1.6. Стратегийн эрдэл - Бизнесийн буруу шийдвэр, алдаатай бизнес төлөвлөгөө, оновчгүй бизнесийн стратегийг биелүүлэх, макро эдийн засгийн өөрчлөлтөнд цаг тухайд нь хариу үйлдэл үзүүлэгүйгээс үүсэх эрдэлүүдийг хэлнэ.
- 3.1.7. Комплаенсийн эрдэл - Хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас тухайн байгууллага хуулийн хариуцлага, эрх бүхий байгууллагын торгууль, шийтгэл хүлээх, санхүүгийн бодит алдагдалд орох, нэр хүндийн эрдэл хүлээхийг хэлнэ.

### Дөрөв. Эрдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шат

- 4.1. Эрдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь хоорондоо харилцан уялдаатай дараах үе шатаас тогтоно. Үүнд:

- 4.1.1. Эрдэлийг тодорхойлох: ББСБ-ын газар, нэгж нь үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гадаад, дотоод орчны хүчин зүйлсийг шинжлэн эрдэлийг цаг алдалгүй тодорхойлно.
- 4.1.2. Эрдэлийг үнэлэх: Эрдэлийн төрөл бүрт чанарын болон тоон шинжилгээг хийн эрдэлийн түвшинг тогтоож цаашид авах арга хэмжээний хувилбарыг тодорхойлж шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.2.1. Тоон шинжилгээ
- 4.1.2.1.1. Зээлийн эрдэл- ECL, PD болон LGD индикатор болон дотоод, гадаад скоринг хийдэг аргууд гэх мэт зээлийн эрдэлийн стандарт үнэлгээний системүүд,
- 4.1.2.1.2. Зах зээлийн эрдэл- Var систем, хүүгийн түвшний эрдэл үнэлдэг Gap шинжилгээний арга,
- 4.1.2.1.3. Хөрвөх чадварын эрдэл- хөрвөх чадварын харьцаанууд,

4.1.2.1.4. Үйл ажиллагааны эрсдэл- Эрсдэлийн матриц, алдагдлын тархалт, бусад энгийн аргууд,

Тоон шинжилгээний аргууд нь дээр дурдсан аргуудаар хязгаарлагдахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд ББСБ-ын зүгээс бусад аргыг хэрэглэж болно.

4.1.2.2. Чанарын шинжилгээ

4.1.2.2.1. Зээлийн эрсдэл- Стресс тест, эрсдэлийн шинжилгээ,

4.1.2.2.2. Зах зээлийн эрсдэл- Зах зээлийн стресс тест болон болзошгүй үйл явдлуудын шинжилгээ,

4.1.2.2.3. Хөрвөх чадварын эрсдэл- Стресс тест болон болзошгүй үйл явдлуудын шинжилгээ,

4.1.2.2.4. Үйл ажиллагааны эрсдэл- Гар шинжилгээ, back testing

4.1.2.2.5. Стратегийн эрсдэл- болзошгүй үйл явдлуудын шинжилгээ,

4.1.2.2.6. Комплаенсийн болон нэр хүндийн эрсдэл- болзошгүй үйл явдлуудын шинжилгээ,

4.1.3. Эрсдэлийг удирдах: Эрсдэлийн удирдлагын дээрхи үе шатуудыг хэрэгжүүлснээр шаардлагатай дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.1.3.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэх эрсдэл, хохирол, орлогоос хамаараад эрсдэлийг хүлээн зөвшөөрөх.

4.1.3.2. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон эсвэл тухайн үйл ажиллагааны эрсдэлийг хангалттай тодорхойлох боломжгүй тохиолдолд уг үйлчилгээг нэвтрүүлэхээс зайлсхийх;

4.1.3.3. Эрсдэлийн төрөл тус бүрт эрсдэлийн хязгаар тогтоох (ББСБ-ын хүлээж болзошгүй эрсдэлийн зохистой хязгаарыг тогтоох);

4.1.3.4. ББСБ нь эд хөрөнгө, үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд ажилтыг даатгалд хамруулж болзошгүй хохирлоос хамгаална. Дараах төрлийн даатгалуудыг зайлшгүй хийлгүүлнэ.

4.1.3.4.а. Эрсдэлд өртөх магадлал их болон хохирлын нөлөөлөл их барилга, үл хөдлөх эд хөрөнгө

4.1.3.4.б. Мэдээллийн технологийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж

4.1.3.4.в. ББСБ-ын өмчлөлийн тээврийн хэрэгслүүдийг тээврийн хэрэгслийн даатгалд

4.1.3.4.д. Жолоочийн хариуцлагын даатгал

4.1.3.4.е. Компанийн удирдлага болон эрсдэлд өртөх магадлал бүхий ажилнуудыг гэнэтийн ослын даатгалд

4.2. Хяналт: Эрсдэлийн төрөл тус бүрийн эрсдэлийн үзүүлэлт бүрт хяналт тавьж ажиллана.

#### Тав. Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

5.1. Компани нь эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх ба эрсдэлийн удирдлагын төвлөрсөн бүтэцтэй байна. Үүнд:

5.2. Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг компанийн бүтэц, зохион байгуулалтанд хамгаалалтын З шугамын хүрээнд дараах байдлаар тусгана. Үүнд:

5.2.1. Төлөөлөн удирдах зөвлөл - Компанийн эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, зарчмыг тодорхойлно;

5.2.2. Дотоод хяналт шалгалтын чиг үүргийг хариуцсан албан тушаалтан – компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилт, компанийн засаглал

- болон бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоо, үр дүнтэй байдал, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж буй бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ТУЗ-д тайлагнаж ажиллана;
- 5.2.3. Гүйцэтгэх удирдлага- ТУЗ-ийн тодорхойлсон эрсдэлийн удирдлагын стратеги, зарчмыг ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;
- 5.2.4. Бусад нэгжүүд- эрсдэлийг илрүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийг зохистой түвшинд удирдах үүрэгтэй.

### **Зургаа. Зээлийн эрсдэлийн удирдлага**

6.1 Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь зээлийн үйл ажиллагаанаас учрах эрсдэл болон хүлээгдэх өгөөжийг хамгийн оновчтой түвшинд байлгахад орших ба дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.1.1 Зээлийг гэрээний дагуу эргэн төлөгдөхийг баталгаажуулсан хангалттай нотолгоо, итгэл үнэмшилтэй болсон тохиолдолд зээлийн харилцааг эхлүүлэх;
- 6.1.2 Зээлийн багцын чанар муудах нөхцөл байдлыг аль болох эрт илрүүлж, зээлийн эргэн төлөлтийг хамгийн их түвшинд байлгахын тулд багцад байнга хяналт тавьж ажиллах;
- 6.1.3 Эдийн засгийн нөхцөл байдал, бүс нутгийн хөгжил, ББСБ-ын салбар нэгжийн онцлог, түүхэн эрсдэлийн тохиолдол зэргийг харгалзахаас гадна судалгаа шинжилгээнд үндэслэн төвлөрлийн хязгаарыг зээлдэгчийн, салбарын, зээлийн хэмжээний болон бүтээгдэхүүнээр тогтоож удирдана.

6.2 ББСБ нь зээл шийдвэрлэх үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримталж ажиллана.

Үүнд:

- 6.2.1 Хариуцлагын тогтолцоо буюу ББСБ-ын эрх бүхий этгээдүүдээс үл хамааран зээлийн шийдвэр гаргалтад хариуцлагатай хандах;
- 6.2.2 Зээлийн өргөдөлд хараат бус байдлаар зээлийн эрсдэлийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- 6.2.3 Зээлийн хороо нь зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагааны журмаар зохицуулсан эрхийн хүрээнд шийдвэр гаргах;
- 6.2.4 Зээлийн хувийн хэрэг, баримтыг шаардлагын түвшинд хангаж бүрдүүлэх;
- 6.2.5 Зээлийн чанарыг тодорхойлох хяналтыг тогтмол тавьж ажиллах;
- 6.2.6 Тогтоосон хязгаарыг мөрдөж, зээлийн багцыг тараан байршуулах;

6.3 ББСБ-ын зээлийн эрсдэлийг үнэлэх үйл явц нь дараах байдалтай байна. Үүнд:

- 6.3.1 ББСБ-ын төв, салбар нэгжийн зээлийн багцад хийдэг судалгаа шинжилгээ, давхцахаас сэргийлэх;
- 6.3.2 Зээлийн үе шатуудад хийдэг хяналтыг ил тод байлгах (зээлийн хүсэлт, шийдвэр гаргалт, олголт, хяналт)
- 6.3.3 Зээлийн эрсдэлийн үнэлгээ нь бодитой байх;
- 6.3.4 Үнэлэх арга, аргачлал нь энгийн, ойлгомжтой байх бөгөөд шийдвэр гаргалт шуурхай байхад чиглэсэн байна.

6.4 Эрсдэлийн удирдлагын нэгж нь ББСБ-ын зээлийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, эрсдэлийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй оролцено. Үүнд:

- 6.4.1 Дотоод журмаар тогтоосон эрхийн хүрээнд зээлийн өргөдөл тус бүрд хөндлөнгийн санал, дүгнэлт гаргаж, холбогдох зээлийн хороодод танилцуулах;
- 6.4.2 Зээлийн судалгаа, шинжилгээн дээр үндэслэн зээлийн эрсдэлийг багасгах арга замыг тодорхойлж, дүгнэлт гаргах;

- 6.4.3 Зээлийн багцад эрсдэлийн судалгаа шинжилгээ хийж, тайлагнах;
- 6.4.4 Ангилал нь буурч болзошгүй зээлийн багцыг урьдчилж илрүүлэх;
- 6.4.5 Зээлийн бодлого, журам, зааврыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих;
- 6.4.6 Зээлийн эрсдэлийг үнэлэхдээ шат дараалсан арга аргачлалыг хэрэглэнэ.
- 6.5 Зээлийн хорооны гишүүдийн олонхийн саналаар зээл олгох эсэх тухай шийдвэр гарна.
- 6.6 Бүх шатны удирдлага өөрийн ажлын чиг, үүргийн агуу ажиллаж зээлийн эрсдэлийн удирдлагын хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 6.7 Зээлийн хороо нь зээлийн бодлого болон эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэх өөрийн үндсэн үүргийнхээ хүрээнд дараах эрх, үүрэг, хариуцлага хүлээнэ.
- 6.7.1 Зээлийн үйл ажиллагаанд оролцож байгаа ББСБ-ын төв, Салбар нэгжүүдийн зээлийн өргөдлийн судалгаа шинжилгээ, дүгнэлтийг хянах;
- 6.7.2 Зээлтэй холбоотой аливаа асуудлыг дэмжих эсхүл татгалзах, түдгэлзах шийдвэр гаргах;
- 6.7.3 Зээлийн нөхцөлийг тодорхойлох (тогоосон нөхцөлийн хүрээнд хэмжээ, хугацаа, эргэн төлөгдөх хуваарь, хүү, шимтгэл гэх мэт);
- 6.7.4 Барьцаа хөрөнгөнд шаардлага тавих (төрөл, үнэлгээ, барьцаалах нөхцел гэх мэт);
- 6.7.5 Холбогдох журмын хүрээнд зээлийн нөхцөлийг өөрчлөх (барьцаа хөрөнгө солих, хүүг өөрчлөх, хугацаа сунгах гэх мэт);
- 6.8 Зээлийг шийдвэрлэх эрх бүхий этгээдүүдийн үүргийн хүрээнд баримтлах үндсэн зарчим:
- 6.8.1 Зээлтэй холбоотой аливаа асуудлыг нэг хүний шийдвэрээр бус олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 6.8.2 Зээлийн эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тухайлсан бүтээгдэхүүний болон багцын хязгаар тогтоо замаар зээлийн багцыг тодорхой түвшинд тараан байршуулах (харилцагчаар, бизнесийн салбараар болон газар зүйн байршилаар), ББСБ-ын нийт активт эзлэх багцыг удирдана.
- 6.8.3 Эрсдэлийн удирдлагын болон зээлийн бодлого, журам, нь мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт тавина.
- 6.9 Зээл судлахаас эхлэн бүрэн төлөгдөх хүртэл зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Зээлийн эргэн төлөлт, зээлдэгчийн санхүүгийн чадавхи, барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээний өөрчлөлт зэрэг үзүүлэлтэд тогтмол мониторинг хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг шуурхай авна.
- 6.10 Эрсдэлийн нэгж нь шаардлагатай тохиолдолд дараах тайлан, мэдээг боловсруулан, Зээлийн хороо, удирдлагад танилцуулна. Үүнд:
- 6.10.1 Зээлийн чанарын тайлан;
- 6.10.2 Томоохон зээлүүдийн тайлан;
- 6.10.3 Зээлийн эрсдэлийн сангийн мэдээ;
- 6.10.4 Эдийн засгийн тодорхой салбарын шинжилгээ;
- 6.11 Зээлийн эрсдэлийн удирдлагыг бусад төрлийн эрсдэлтэй холбон авч үзнэ.

### Долоо. Зах зээлийн эрсдэлийн удирдлага

- 7.1 ББСБ нь зах зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, зохистой удирдах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хянах замаар удирдлагын үр ашигтай системийг тусгаж хэрэгжүүлнэ.

7.2 ББСБ-ын зах зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэх хохирлыг хамгийн бага түвшинд барьж ажиллахад оршино.

7.3 Зах зээлийн эрсдэлийн удирдлагын зарчим

- 7.3.1 Зах зээлийг байнга ажиглаж өөрчлөлтийг тухай бүр мэдэрч байх;
- 7.3.2 Газар, хэлтэс, алба нь уялдаа холбоотой ажиллаж зах зээлийн эрсдэлийн талаарх мэдээллийг тасралтгүй солилцдог байх;
- 7.3.3 Зах зээлийг бодитоор илэрхийлэх мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийдэг байх;
- 7.3.4 Зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийг хянаж, удирдлагыг тогтмол мэдээллээр хангаж тайлагнадаг байх;
- 7.3.5 Тогтоосон хязгаарт эрсдэлийг хамгийн бага түвшинд барьж ажиллахыг эрмэлзэг байх;
- 7.3.6 Эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлдэг байх;
- 7.3.7 Эрсдэлийн үнэлгээний аргачлал болон дүгнэлтэд эргэн хяналт хийж сайжруулдаг байх.

7.4 Зах зээлийн эрсдэлийн удирдлагын үе шат:

- 7.4.1 Зах зээлийг тодорхойлохдоо дараах байдлаар тодорхойлно.
  - 7.4.1.1 Зах зээлийн өнгөрсөн цаг хугацааны шинж чанар давтамжийг тодорхойлох;
  - 7.4.1.2 Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн хандлагыг ажиглах, таамаглах;
  - 7.4.1.3 Зах зээлд гарсан өөрчлөлт бүрийг тухай бүр мэдэрч түүнээс үүдэх эрсдэлийг тодорхойлох.

7.5 Зах зээлийн эрсдэлийг дараах байдлаар үнэлнэ:

- 7.5.1 Зах зээлийн бодит мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийнэ;
- 7.5.2 Эрсдэлийг тооцоолох загварын илэрхийлэх чадварыг бодит мэдээлэлтэй харьцуулах замаар буцаан шалгалт хийнэ.

7.6 Эрсдэлийн түвшин зөвшөөрсөн хязгаараас давсан тохиолдолд залруулах арга хэмжээг шуурхай авна.

7.7 Зах зээлийн эрсдэлийн хяналт, тайлагнал

- 7.7.1 Зах зээлийн өөрчлөлтийг байнга хянаж, зах зээлийн өөрчлөлтөөс үйл ажиллагаанд нөлөөлех нөлөөллийг тооцоолж эрсдэлийн удирдлагын хороонд тухай бүр тайлагнана.
- 7.7.2 Зөвшөөрсөн эрсдэлийн хязгаарт хяналтыг байнга тавьж, боловсруулсан холбогдох тайланг Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол танилцуулна.

### **Найм. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага**

8.1 ББСБ нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг зохицуулах журамтай байх бөгөөд уг журамд үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, зохистой удирдах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хянах замаар удирдлагын үр ашигтай системийг бүрдүүлж хэрэгжүүлнэ.

8.2 Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын зорилго нь тухайн эрсдэлийг үүсэхээс урьдчилан сэргийлэх, учирсан эрсдэлийн хохирлыг хамгийн бага түвшинд оновчтой удирдахад оршино.

8.3 Үйл ажиллагааны эрсдэлийг үүсгэгч шалтгаанаар нь дараах байдлаар ангилик болно.

8.3.1 Хүний хүчин зүйл - ББСБ-д хохирол учруулахаар ажилтны санаатай, санамсаргүй үйлдэл

8.3.2 Процесс - Дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам зааврын зөрчилтэй байдал,

8.3.3 Автоматжуулсан систем- мэдээллийн технологийн систем, программ хангамж, үйл ажиллагааг автоматжуулсан систем зэргийн доголдол

8.3.4 Гадаад хүчин зүйл – Байгалийн гамшиг, улс төрийн сөрөг нөлөө, улс орны санхүүгийн сүл бодлого, заилиан

8.4 ББСБ нь оновчтой үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд дараах зарчмуудыг баримтална.

8.4.1 ББСБ-ын бүх шатны албан тушаалтнууд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагатай холбоотой өөр өөрсдийн үүрэг хариуцлагыг ойлгож мэдсэн байна.

8.4.2 Ажилтан бүр өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих.

8.4.3 Ажилтан бүр ББСБ-д учирсан томоохон хэмжээний, аюултай, нэр хүндэд муугаар нөлөөлөхүйц, хууль бус тохиолдлуудыг нэн даруй шууд удирдлагад мэдэгдэж байх.

8.4.4 ББСБ нь бүхий л үйлчилгээ, үйл ажиллагаа болон системд оршиж байгаа эрсдэлийг тодорхойлох.

8.4.5 Эрсдэлийг цаг алдалгүй илрүүлэх, бүртгэх, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авах.

8.4.6 Газар, хэлтэс, албуур үялдаа холбоотой ажиллаж, үйл ажиллагааны эрсдэлийн талаарх мэдээллийн тасралтгүй урсгалыг бий болгох.

8.4.7 Үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг байнга хянаж, удирдлагыг тогтмол мэдээллээр хангадаг байх.

8.4.8 Эрсдэлийн суурь шалтгааныг тодорхойлж арга хэмжээ авах.

8.5 Үйл ажиллаагааны эрсдэлийн удирдлагын үе шат

8.5.1 Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлоходоо дараах арга замуудыг ашиглана.

8.5.2 ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийн дотоод болон гадаад мэдээллийг хамруулсан эрсдэлийн мэдээлэлд шинжилгээ хийн эрсдэлийг тодорхойлох;

8.5.3 ББСБ-ын газар, хэлтэс, албаны үйл ажиллагаа, үйлчилгээнд шинжилгээ хийж эрсдэлийг тодорхойлох;

8.5.4 Цаг үеийн нөхцөл байдалд шинжилгээ хийн эрсдэлийг тодорхойлох

8.5.5 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд шинжилгээ хийх.

8.6 Үйл ажиллагааны эрсдэлийг ББСБ-ын явуулж буй үйл ажиллагаа, үйлчилгээ, түүнийг зохицуулсан бодлого болон журам, ажлын үялдаа холбоо, ажилтны ёс зүй болон ур чадвар, ажиллах орчин нөхцөл, техник болон программ хангамж зэргийг хамруулан тодорхойлно.

8.7 Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэхдээ доорх арга, хэрэгслүүдийг ашиглана.

8.7.1 Үйл ажиллагааны эрсдэлийг илэрхийлэх түлхүүр үзүүлэлтийг тодорхойлж үнэлэх,

8.7.2 Газар, хэлтэс, албаны үйл ажиллагаа, үйлчилгээнд эрсдэл ба хяналтын үнэлгээ хийх.

8.7.3 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар эрсдэлийн хохирлын хязгаарыг тогтоох, аргачлалыг сайжруулах.

8.7.4 Бусад судалгаа шинжилгээнд тулгуурласан эрсдэлийн үнэлгээний арга.

8.8 Үйл ажиллагааны эрсдэлийг удирдахдаа доорх арга хэмжээнээс оновчтойг сонгон хэрэгжүүлнэ.

8.8.1 Үйл ажиллагааны эрсдэл үүсч болзошгүй гараар хийдэг үйлдлүүдийг аль болох автоматжуулах,

- 8.8.2 Тухайн эрсдэлийн онцлогоос хамааран эрсдэлээс зайлсхийх болон шилжүүлэх,
- 8.8.3 Онцгой нөхцөл байдал үүссэн үед үйл ажиллагаа болон санхүүжилтийг хэвийн болгоход чиглэсэн “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан, хэрэгжүүлэх,
- 8.8.4 Бага эрсдэлтэй гэж тодорхойлогдсон эрсдэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авна.
- 8.8.4.1 Үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх талаарх ажилтнуудад заавар, зөвлөмж хүргүүлэх,
- 8.8.4.2 Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах,
- 8.8.4.3 Шаардлагатай гэж үзвэл компанийн холбогдох заавар, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр заавар, журам боловсруулах,
- 8.9 Үйл ажиллагааны эрсдэлийн хяналт, тайлагнал
- 8.9.1 Эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүдэд хязгаар тогтоох, хязгаарын хүрээнд хяналт тавих,
- 8.9.2 Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих,
- 8.9.3 Аудитын болон аудитын бус шалгалтаар илэрсэн зөрчлийн эрсдэлийг тодорхойлж, судлах,
- 8.9.4 Үйл ажиллагааны эрсдэлийн төлөв байдлын талаар тайлан боловсруулж хянах,
- 8.9.5 Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог ББСБ-ын эрх бүхий албан тушаалтнууд хянана.

#### **Ес. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага**

- 9.1 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын гол зорилго нь зах зээлийн хэвийн, хэвийн бус нөхцөлд аливаа гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадахуйц бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрвөх чадвартай хөрөнгийн зохистой нөөцтэй байх, түүнчлэн компанийн ашигт ажиллагааг зохистой тувшинд барихад оршино.
- 9.2 Хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэхдээ дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.2.1 Хөрвөх чадварыг богино, дунд болон урт хугацаанд ангилж шинжлэх;
- 9.2.2 Макро эдийн засгийн судалгаа хийх;
- 9.2.3 Өнгөрсөн цаг хугацааны тоон мэдээлэл болон ирээдүйд үүсч болзошгүй нөхцөл байдлын талаарх төсөөлөлд үндэслэн хөрвөх чадварын хандлагыг тодорхойлох;
- 9.2.4 “Хөрвөх чадварын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан батлаж, дотоод болон гадаад нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөн үед шинэчилж байх.
- 9.3 Хөрвөх чадварын эрсдэлийн арга хэмжээ нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:
- 9.3.1 Дэлхий, бус нутаг болон улс орны эдийн засгийн нөхцөл байдал, бусад гадаад болон дотоод хүчин зүйлийн өөрчлөлттэй уялдуулан, хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээнд зохицуулалт хийх;
- 9.3.2 Хөрвөх чадварт нөлөөлөхуйц эрсдэлээс зайлсхийх,
- 9.3.3 “Хөрвөх чадварын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх.

#### **Арав. Нэр хүндийн, стратегийн болон комплаенсийн эрсдэл**

- 10.1 Олон нийтэд тарсан сөрөг сэтгэлдээс үүдэж ББСБ нь шинэ гэрээ, үйлчилгээ гаргах, хуучин гэрээ, үйлчилгээг амжилттай үргэлжлүүлэхэд саад болсноор санхүүгийн

тайландаа сөрөг нөлөө үүсгэх боломжтой эрсдэлийг хэлэх бөгөөд ажилтан бүр ёс зүйн дүрмийг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, харилцагчтай харилцах харилцаа, үйлдэл, үйл ажиллагааг хянаж ББСБ-ын нэр хүндийг ямагт хамгаалах үүрэгтэй.

10.1.1 Нэр хүндийн эрсдэлийн төрөл:

- 10.1.1.1 Гол үйл ажиллагааны явцад бодлогын зүй бус үйлдэл гаргасан
- 10.1.1.2 Голлох хувьцаа эзэмшигчийн зүй бус үйлдэл, олон нийт сөрөг сэтгэгдэл үүсэх

10.1.2 Нэр хүндийн эрсдэл дараах санхүүгийн дараах эрсдэлүүдтэй уялдаатай байдаг:

- 10.1.2.1 Хөрвөх чадварын эрсдэл- Олон нийтэд сөрөг сэтгэгдэл үүсгэснээр депозит эзэмшигчид мөнгөө татан авах, харилцагчид үйлчилгээ авахаас татгалзах
- 10.1.2.2 Зээлийн эрсдэл- Компанийн нэр хүндэд нөлөөлж болохуйц үйл ажиллагаанд хөрөнгө оруулах
- 10.1.2.3 Үйл ажиллагааны эрсдэл- Байгууллагын бүтэц болон менежментэд томоохон өөрчлөлт орох нь ажилчдын шилжилт хөдөлгөөн, үйлчилгээний чанарт нөлөөлж болно. Харилцагчийн “Муу” үйлчилгээ болон мэдээллийн буруу урсгал нь харилцагчийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлдөг.

10.2 Стратегийн эрсдэл нь байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнес төлөвлөгөө хэрэгжилт муу, зах зээлийн өөрчлөлтийг дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн өсөлт буурах, алдагдал хүлээх эрсдэлийг ойлгоно.

10.3 Комплаенсийн эрсдэл нь ББСБ-ын үйл ажиллагаанд хамаарах, мөрдөгдөх хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамж алдагдах эрсдэлийг ойлгоно. Эрсдэл, хяналтын тогтолцоонд хамгаалалтын гурван шугамын загварыг үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

**Арван нэг. Эрсдэлийн шинжилгээ ба тайлгиналт**

11.1 ББСБ нь бүхий л үйл ажиллагаанд хяналтын тогтолцоог бий болгож, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорих бөгөөд болзошгүй эрсдэлийн тохиолдолд хүлээж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, тэдгээрийг цаг алдалгүй удирдах зорилгоор эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийдэг байна.

11.2 ББСБ нь эрсдэлийн тайланг бэлтгэн улирал тутамд Төлөөлен удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулна.

**Арван хоёр. Хяналт, хариуцлага**

12.1 ББСБ-ын үйл ажиллагаанд гарч болох эрсдэлийг бууруулах зорилгоор шат дараалсан болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хяналтыг компанийн холбогдох албан тушаалтнууд батлагдсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэнэ.

12.2 ББСБ-ын ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, бодлого, журам, заавар, гарын авлага, аргачлалын дагуу ажил үүргээ гүйцэтгэж үнэнч

шударгаар ажиллана. Мөн компани хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримтлана.

12.3 ББСБ-ын ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, банк бус санхүүгийн байгууллагын хэмжээнд хэрэглэж буй журам, заавар, компанийн газар, нэгжийн дотоод үйл ажиллагааны журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон ажилтны ажлын байрны тодорхойлолтоор зохицуулна.

----- oOo -----



## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

“Сэндли БСБ” ХК /цаашид “Сэндли” гэх/ нь эрх бүхий этгээдээс олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагын хувьд дотоод, гадаад харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах зорилгоор энэхүү баримт бичгийг боловсруулав.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын бичиг баримтыг боловсруулахдаа ISO/IEC 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартыг баримтална.

### Хоёр. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

2.1. Сэндли нь дараах аюулгүй байдлыг хангаж ажиллана. Үүнд:

- 2.1.1. харилцагчид үзүүлж буй бүх торлийн санхүүгийн үйлчилгээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
  - 2.1.2. мэдээллийн аюулгүй байдлын сайн соёлыг байгууллагад бий болгох;
  - 2.1.3. Сэндли нь харилцагчид, хөрөнгө оруулагчид, технологийн түншүүд, гуравдагч талуудтай хамтран ажиллахдаа мэдээллийн нууцлал, түүний бүрэн бүтэн байдал, хүргээмжтэй байдлыг бүрэн хангах.
- 2.2. Кибер аюулгүй байдлыг хангаж, хэрэглэгчийн найдвартай түвш байж ёс суртахууны болон хууль ёсны хариуцлагыг сахин хамгаална.
- 2.3. Сэндлигийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, өгөгдөл, оюуны өмч, хөрөнгө оруулагч, хувь хүний мэдээллүүд бүгд үнэ цэн бүхий хөрөнгөд тооцогдох бөгөөд уг мэдээлэл устах, алдагдах, гадны халдлагад өртөх гэх мэт болзошгүй эрсдэлийг бууруулж ажиллана.
- 2.4. Мэдээллийн аюулгүй байдал /цаашид “МАБ” гэх/-ыг хангаж, МАБ-ын удирдлагын тогтолцооны тохиромжтой, хангалттай, үр нөлөөтэй байдлыг 2 жил тутам хянаж, тасралтгүй сайжруулж ажиллана.

### Гурав. Мэдээллийн аюулгүй байдлын зорилго

3.1 МАБ-ын бодлогын хүрээнд дараах зорилгуудыг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

3.1.1 МАБ-ын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь журам, заавраар зохицуулагдсан байх бөгөөд ISO 27001:2013 стандартыг хангасан байгууллага байна. Үүнд:

- Мэдээлэл, өгөгдөл болон түүнтэй холбоотой үйл явц, мэдээллийн технологийн систем, сүлжээ нь Сэндлигийн өмч бөгөөд компанийн бусад өмчийн нэгэн адил хамгаалагдаж, бүртгэгдсэн байна.
- Сэндлигийн харилцагч, хөрөнгө оруулагч, технологийн түншүүд, бусад хамтрагч байгууллагуудын мэдээлэл бүрэн бүтэн байх шаардлагын дагуу мэдээллийг дамжуулах, боловсруулах явцад үүсч болох санамсаргүй болон санаатай өөрчлөлтүүдийг хянаадаг тогтолцоотой байх бөгөөд гарч болох эрсдэлийг тогтмол бууруулж ажиллана.
- Мэдээлэл, мэдээллийн технологийн систем нь халдашгүй, нууцлалтай байна. Мэдээлэл, мэдээллийн технологийн систем нь нууцын зэргээр ангилагдах бөгөөд эрх олгогдоогүй этгээдэд хаалттай, хандах боломжгүй байж, хууль бус хандалтаас хамгаалагдан шифрлэгдсэн байна.
- Сэндлигийн мэдээлэл хүргээмжтэй байна. Мэдээлэл, мэдээллийн технологийн системүүд нь нууцын зэргээр ангилагдаж эрх бүхий этгээд цаг алдалгүй хандах, ашиглах боломжтой байна.

- Сэндлигийн мэдээллийн технологийн систем, сүлжээний дэд бүтцэд нэвтэрч буй нийт хэрэглэгчдэд, хандах эрх олгогдож, сүлжээнд адилтган танигддаг байна. Сүлжээний дэд бүтцэд хандах эрх нь хяналтад байна.
- 3.2 Энэхүү бодлогын биелэлт, техник технологийн дэвшлийг харгалзан шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд компанийн ТУЗ-ийн тогтоолоор батална.

#### **Дөрөв. Мэдээллийн аюулгүй байдлын зорилт**

- 4.1. Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд дараах журам, заавар, төлөвлөгөөг боловсруулан, Сэндлигийн нийт ажилтнууд танилцаан өдөр тутмын ажилд хамаарах хэсгүүдийг дагаж мөрдөж ажиллах зорилтыг тавьж ажиллана. Үүнд:
  - 4.1.1.Мэдээлэл, мэдээллийн технологийн системийн нууцын журам
  - 4.1.2.Мэдээллийг хадгалах, хамгаалах, нөөцлөх журам
  - 4.1.3.Сүлжээ, сүлжээнд холбогдох тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын журам
  - 4.1.4.Программ хангамжийн журам
  - 4.1.5.Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам
  - 4.1.6.Мэдээллийн аюулгүй байдалд шалгалт хийх журам
  - 4.1.7.Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн үед ажиллах журам
  - 4.1.8.Мэдээлэл, мэдээллийн технологи систем сүлжээнд хандах хандалтыг хянах журам
  - 4.1.9.Бизнесийн мэдээлэл, мэдээллийн системийн үйл ажиллагааны тасралтгүй байдлын болон гэнэтийн аюулаас сэргээх төлөвлөгөө
  - 4.1.10. Баримт бичгийн хяналтын журам
  - 4.1.11. Байр, байшигийн аюулгүй байдлын заавар
- 4.2. Сэндли нь ажилтнуудын МАБ-ын сургалтанд хамрагдсан байдлыг 100 хувьд хүргэж ажиллана.
- 4.3. Сэндли нь МАБ-ын эрсдэлийн үнэлгээг жил бүр, томоохон өөрчлөлт хийх бүрт тухай бүр хийж байгууллагын эрсдэлийг бага түвшинд байлгана.
- 4.4. МАБ-тай холбоотой зөрчлийн шийдвэрлэлтийг бүрэн шийдвэрлэж байна.

#### **Тав. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хамрах хүрээ**

5.1 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- 5.1.1: Олон улсын мөнгөн гүйвуулгын үйлчилгээ
- 5.1.2: Зээлийн үйлчилгээ
- 5.1.3: Итгэлцлийн үйлчилгээ

5.2 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд мэдээлэл, мэдээллийн технологийн систем нь дараах агуулгыг хамрана.

5.2.1 Мэдээлэл нь:

- Сэндлигийн эзэмшлийн, ашигладаг, санхүүжүүлсэн бүхий л төрлийн мэдээлэл;
- Сэндлигийн оюуны өмчид хамаарах бүх төрлийн мэдээлэл,
- Хэрэглэгч, хөрөнгө оруулагч, технологийн түншүүд, гуравдагч талуудад дамжуулж буй мэдээлэл,
- Компанийн үйл ажиллагаа явуулахад ашиглагдаж буй бусад бүх төрлийн мэдээллийг ойлгоно.

5.2.2 Мэдээллийн технологийн систем нь:

- Сэндлигийн эзэмшлийн, захиалгын, ашигладаг, санхүүжүүлсэн бүх төрлийн мэдээллийн систем, түүний дэд бүтэц, програм хангамж, үйлчилгээ, бүх төрлийн сүлжээ, холболт, компьютерээр удирдагддаг төхөөрөмж, нөөцүүд, тэдгээрийг хөгжүүлэхтэй холбогдсон аюулгүй байдлын үйл ажиллагаа.

- Тухайн компанид хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн мэдээлэл, МТ-ийн системийг ойлгоно.

#### 5.2.3 Хүний нөөц:

- Компанийн эзэмшлийн мэдээлэл, МТ-ийн систем дээр ажиллаж байгаа хэрэглэгчийг ойлгоно.

#### 5.2.4 Биет орчин:

- Сэндлигийн үйл ажиллагаа явуулж буй оффисын барилга, салбар нэгжүүдийн байршиж буй байршил;
- Дата төв, компьютер, бүх төрлийн техник хангамжийг ойлгоно.

5.3 Сэндлигийн хэрэгжүүлж буй төслүүдэд төслийн төрлөөс үл хамааран мэдээллийн аюулгүй байдал хэрэгжино.

## СЭНДЛИ ББСБ ХК

**Мэдээллийн аюулгүй байдлын бодлого "Хавсралт №1"**

<b>1</b>	<b>Мэдээллийн аюулгүй байдлын бодлого</b>	Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг 2 жил тутам зайлшгүй шинэчлэх богоёд шаардлагатай үед холбогдох хурлаар хэлэлцүүлж бодлого журамд өөрчлөлт оруулж байна.
<b>2</b>	<b>Хүний нөөц болон бусад нооц</b>	Жил бүрийн төсвийг хэлэлцэн батлахдаа МАБ-тай холбоотой нөөцийг хэлэлцэн. Систем, хүний нөөц, техник гэх мэт
<b>3</b>	<b>Ажил эрхлэх хугацаанд</b>	Шинэ ажилтныг ажилд орсноос хойш ажлын 21 хоногийн дотор МАБ-ын сургалтанд хамруулна. Бусад тохиолдолд шаардлагатай үед хамрах хүрээний ажилчдыг хамруулан сургалтыг зарлан оруулна. Сургалт тус бүрт хамрагдах шаардлагатай ажилчдын оролцоог 100 хувь байхаар зохион байгуулна.
<b>4</b>	<b>Эрдлийн үнэлгээ</b>	Эрдлийн үнэлгээг 2 жил бүр шаардлагатай үед тухай бүр хийлгэнэ. Их, өндөр эрдлийг тухай бүр бууруулна. Эрдлийн үр дүн дунд түвшнээс дээш гарахгүй байх
<b>5</b>	<b>Хэрэглэгчийн хандалтын удирдлага</b>	Хэрэглэгчийн хандалтын мониторингийг Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан болон дотоод аудитор жил бүр зохион байгуулна. Бүх системд хэрэглэгчийн хандалтын хяналт 95 хувиас доошгүй, нууц үгийн чанар 95 хувиас доошгүй байлгана.
<b>6</b>	<b>Хэрэглэгчийн хандалтын эрхийг нягтлан шалгах</b>	Хэрэглэгчийн хандалтын эрхийн зохицуулалтын хяналтыг дотоод аудитор хагас жилд нэг удаа шалгана. Үр дүнгээс хамааран доорхи арга хэмжээнээс хэрэгжүүлнэ. Үр дүн 90-100 хувь байвал ХЭВИЙН гэж үзээ, 70-90 хувь бол АНХААРАХ шаардлагатай гэж үзэн дараагийн улирлын хяналтанд сайжруулалтыг хянана, 70 аас доош хувь бол ЯАРАЛТАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ шаардлагатай гэж үзэн даруй засварлах арга хэмжээ авна.
<b>7</b>	<b>Нууц үг</b>	Дотоод аудитор улирал бүр байгууллагын маш нууц мэдээлэлтэй ажилладаг ажилтинуудын нууц үгийн чанарыг шалгана. Бусад бүх ажилтинуудын нууц үг байгууллагын нууц үгийн бодлогод нийцээн байна. Байгууллагын нууц үгийн бодлогыг жил бүр шинэчлэнэ.
<b>8</b>	<b>Криптограф</b>	Шифрлэлтийн бодлого гаргаж, зорилтоо тодорхойлж гүйцэтгэйг 90 хувьд хүргэнэ.
<b>9</b>	<b>Үл тохирол, зөрчил</b>	Илэрэн үл тохирлыг 80 хувь засаж бууруулж байна. Өмнөх үл тохирлоосоо ямагт буурсан үзүүлэлттэй байна. Хэмжих нэгжийг жил бүр шалгаж байна. а) [Одоогоор хэрэгжээгүй залруулах арга хэмжээг] [Одоогоор төлөвлөсөн залруулах арга хэмжээ] гэж хуваана. б) [Шалтгаангүйгээр хэрэгжүүлээгүй залруулах арга хэмжээг] [Өнөөдрийг хүртэл төлөвлөсөн залруулах арга хэмжээ] гэж хуваана. в) Статусуудыг өмнөх статустай харьцуулах
<b>10</b>	<b>Физик хяналт</b>	1. Доод тал нь 3 дугаар зэрэглэлийн хамгаалалтын системтэй байна. 2. Нэвтрэх карт эсвэл PIN кодыг нэвтрэх хяналтад ашигладаг нэвтрэх картын системтэй байна.
<b>11</b>	<b>Барилга байгууламж</b>	1. Ажилтан, барилга байгууламж, бүтээгдэхүүний иж бүрэн аюулгүй байдал, хариуцлагатай орчинг бүрдүүлэх 2. Байгууллагын мэдээллийн нооцийн зохих хамгаалалтыг хангахын тулд биет болон мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтын механизмыг бий болгох. Байгууламжид зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлого 10 хувь хүрэхгүй байх. Хагас жилд ирг удаа логийг нягталдаг байх.
<b>12</b>	<b>Тоног төхөөрөмжийн үйлчилгээ</b>	Засвар үйлчилгээний хийгдээгүй сунгагдсан хугацаа 3 хоногоос хэтэрсэн байх ёсгүй. Бүх засвар бүртгэгдэж хийгдээгүй үйлчилгээ 0 байх ёстой
<b>13</b>	<b>Өөрчлөлтийн удирдлага</b>	Улирал бүр МАБ менежерт өөрчлөлтийн менежментийн бодлогыг хянах жил бүр менежментэд тайлагнаж байх.
<b>14</b>	<b>Хортой програмын эсрэг хяналт</b>	Хортой кодын бодлоготой байх. Хортой кодоос хамаарсан зөрчлийн тоо, блоклогдсон халдлагын тоог бүртгэж харьцуулж байх. Бодлогод жил бүр өөрчлөлт оруулж байх. Өдор бүр хортой кодыг шалгадаг байх. Вирусын тоо 0 байх.

15	<b>Техникийн эмзэг байдлын үнэлгээ</b>	МТ үйлчилгээний downtime хугацааг бүртгэж байх. Сар бүр тайлан гаргаж байх. Бүртгэх боломжтой системийн жагсаалтыг гаргасан байх.
16	<b>Файрволл</b>	Хагас жил тутам эсхүл жил тутам файрволын ашиглагддагтүй дүрмийг тодорхойлж байх.
17	<b>Үйл явцын бүртгэл</b>	Сар бүр лог файл цуглуулж, анализ хийнэ. Хэрэв маш чухал систем бол өдөр бүр хийж болно. Улирал бүр тайлан бэлтгэж, 2 жил тутам логийн бодлогыг шинэчилн. Ажлын үр дүн 80 хувьс дээш байна.
18	<b>Техникийн эмзэг байдлын хяналт</b>	Бодлого журмын дагуу техникийн нийцэл 100 хувь байна Онц чухал гэж тогтоогдсон систем бүрт 75-100 хувь жил бүр pen.test хийлгэсэн байна.
19	<b>Сүлжээг тусгаарлах</b>	Файрволын дүрмийг жил бүр шалгаж нягалж байна.
20	<b>Мэдээлэл харилцаа холбоо технологийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ</b>	Гуравдагч талтай байгуулах гэрээний шаардлагыг 2 жил тутам засаж сайжруулж байна. Гуравдагч талтай байгуулах МАБ-ын гэрээний шаардлага 100 хувь хангасан байх
21	<b>Аюулгүй байдлын сул талын тухай мэдээлэх</b>	МАБ-ын зөрчлийн бүртгэл, шийдвэрлэсэн байдал. Жил бүр шалгаж нягтлан дахиж гаргахгүй байх арга хэмжээг хэлэлцнэ. Бүх тохиолдлуудад дүн шинжилгээ хийсэн байх. Тодорхой ангилал бүрээр дүн шинжилгээ хийж байх
22	<b>Мэдээллийн аюулгүй байдлын бие даасан дүн шинжилгээ</b>	1.Жил бүр дотоод аудит хийж байх. 2. 1 жил тутам баталгаажуулах эсхүл магадлах аудитийн үнэлгээ хийлгэж байх
23	<b>Техникийн нийцлийг шалгах</b>	Жилд нэг удаа эмзэг байдлын үнэлгээ/pen test хийлгэж, эмзэг байдал илэрвэл тогтмол бууруулж ажиллана.